



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/129-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн

Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар

Ахлах аудитор Ч.Анхбаяр

Утас: 8511-6555

Цахим хаяг: ankha964@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.3 Нэмэлт төсөв.....	14
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	14
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	14
3.5.6 Ерөнхий чиглэлийн судалгааны талаар	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага.....	17
5.2 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 86
танай _____-ны № _____-т

БАТЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,746,740.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 96,644.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 148,892.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,840.0 мянган төгрөг, нийт 2,995,117.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, төсвийн зардлын нийт гүйцэтгэлээр 2,764,798.5 мянган төгрөг буюу 92,31 хувьтай зарцуулж, төрийн сангийн дансанд 147,403.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 84.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАИЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>256,349,035.24</u>	<u>286,292,439.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	156,525,814.85	147,403,548.89
312	Банканд байгаа бэлэн мөнгө	156,525,814.85	147,403,548.89
3121	Төгрөг	156,525,814.85	147,403,548.89
31211	Төрийн сангийн харилцах	156,525,814.85	147,403,548.89
35	БАРАА МАТЕРИАЛ	99,823,220.39	138,888,890.39
351	Түүхий эд материал	2,922,000.00	2,922,000.00
35130	Эм боох материал	2,922,000.00	2,922,000.00
354	Хангамжийн материал	96,901,220.39	135,966,890.39
35410	Бичиг хэргийн материал	45,000.00	45,000.00
35420	Аж ахуйн материал	86,504,850.26	125,570,520.26
35470	Бусад хангамжийн материал	10,351,370.13	10,351,370.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,503,958,150.27</u>	<u>1,583,048,104.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,503,958,150.27	1,583,048,104.98
392	Биет хөрөнгө	1,451,602,350.27	1,530,692,304.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,585,656,337.09	1,585,656,337.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(374,765,452.30)	(449,372,339.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,300,000.00	29,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,416,666.43)	(28,079,166.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	292,009,082.05	399,964,757.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(153,298,225.27)	(199,411,594.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	186,155,503.24	291,189,556.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(122,114,914.15)	(140,323,413.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,034,152.20	29,895,772.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,577,854.95)	(18,945,077.91)
39217	Ном	27,620,388.79	30,817,475.29
393	Биет бус хөрөнгө	52,355,800.00	52,355,800.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,425,000.00)	(1,425,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,280,800.00	52,280,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,760,307,185.51</u>	<u>1,869,340,544.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,745,154.00</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,745,154.00	-
413	Өглөг	5,745,154.00	-
4136	Бусад өглөг	5,745,154.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	5,745,154.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,754,562,031.51</u>	<u>1,869,340,544.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,754,562,031.51	1,869,340,544.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	864,114,528.62	864,114,528.62
51101	Өмч: - төрийн	864,114,528.62	864,114,528.62
512	Хуримтлагдсан үр дүн	(33,254,751.37)	81,523,761.38
51210	Өмнөх үеийн үр дүн	(33,254,751.37)	(33,254,751.37)
51220	Тайлант үеийн үр дүн		114,778,512.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	923,702,254.26	923,702,254.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,760,307,185.51</u>	<u>1,869,340,544.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,613,381,985.13	2,427,178,054.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,257,985.13	213,092,254.30
120	Нийтлэг татварын бус орлого	15,257,985.13	213,092,254.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	4,145,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,145,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	8,573,235.00	184,649,534.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	2,498,450.13	24,296,920.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,598,124,000.00	2,214,085,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,518,802,200.00	2,095,740,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,095,740,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,518,802,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,321,800.00	118,345,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,321,800.00	118,345,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,585,134,415.24	2,312,399,541.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,585,134,415.24	2,312,399,541.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,519,508,026.24	2,244,316,285.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,056,105,282.27	1,627,292,971.17
210101	Үндсэн цалин	712,182,677.76	916,905,836.37
210102	Нэмэгдэл	275,248,148.63	562,599,904.80
210104	Урамшуулал	68,674,455.88	147,787,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,944,904.20	203,262,936.53
210201	Тэтгэврийн даатгал	92,943,277.20	135,230,336.53
210202	Тэтгэмжийн даатгал	11,274,705.00	17,008,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,019,344.00	8,504,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,246,378.00	8,504,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,461,200.00	34,016,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,446,066.00	113,034,850.00
210301	Гэрэл, цахилгаан	22,152,256.00	25,630,526.00
210302	Түлш, халаалт	42,899,570.00	83,486,500.00
210303	Цэвэр, бохир ус	3,394,240.00	3,917,824.00

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	2,616,095.00	1,339,940.00
210401	Бичиг хэрэг	75,000.00	1,339,940.00
210402	Тээвэр, шатахуун	2,541,095.00	
2105	Норматив зардал	58,157,599.00	70,318,336.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		300,850.00
210502	Хоол, хүнс	58,157,599.00	70,017,486.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,984,240.00	7,079,450.00
210604	Урсгал засвар	6,984,240.00	7,079,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,228,000.00	19,108,148.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	686,300.00	1,145,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,541,700.00	17,962,348.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,025,839.77	202,569,303.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,660,931.72	44,117,964.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,745,681.00	13,492,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	148,619,227.05	144,958,479.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,626,389.00	68,083,256.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,303,961.00	68,083,256.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,303,961.00	60,170,456.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		7,912,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	5,322,428.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,322,428.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28,247,569.89</u>	<u>114,778,512.75</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>28,247,569.89</u>	<u>114,778,512.75</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,601,124,000.00</u>	<u>2,218,231,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,186,300.00	4,145,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,186,300.00	4,145,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	4,145,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,186,300.00	1,145,800.00

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,598,124,000.00	2,214,085,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,518,802,200.00	2,095,740,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,095,740,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,518,802,200.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,321,800.00	118,345,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,321,800.00	118,345,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,435,088,964.19	2,187,954,965.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,435,088,964.19	2,187,954,965.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,364,322,300.19	2,110,445,325.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,056,105,282.27	1,627,292,971.17
210101	Үндсэн цалин	712,182,677.76	916,905,836.37
210102	Нэмэгдэл	275,248,148.63	562,599,904.80
210104	Урамшуулал	68,674,455.88	147,787,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,944,904.20	203,262,936.53
210201	Тэтгэврийн даатгал	92,943,277.20	135,230,336.53
210202	Тэтгэмжийн даатгал	11,274,705.00	17,008,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,019,344.00	8,504,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,246,378.00	8,504,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,461,200.00	34,016,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,633,322.00	113,345,200.00
210301	Гэрэл, цахилгаан	22,472,256.00	25,630,526.00
210302	Түлш, халаалт	43,163,620.00	83,796,850.00
210303	Цэвэр, бохир ус	3,997,446.00	3,917,824.00
2105	Норматив зардал	50,331,100.00	66,446,370.00
210502	Хоол, хүнс	50,331,100.00	66,446,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,677,050.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	6,677,050.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,228,000.00	19,108,148.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	686,300.00	1,145,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,541,700.00	17,962,348.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,402,641.72	72,950,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,767,760.72	57,422,570.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,634,881.00	15,527,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,766,664.00	77,549,070.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,444,236.00	77,549,070.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	65,444,236.00	69,636,270.00

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		7,912,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,322,428.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,322,428.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>167,221,335.81</u>	<u>30,276,634.04</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,128,995.00	39,398,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,128,995.00	39,398,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,128,995.00	39,398,900.00
223001	Бусад хөрөнгө	37,128,995.00	39,398,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(37,128,995.00)</u>	<u>(39,398,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	128,906,040.81	(9,122,265.96)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		156,525,814.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	156,525,814.85	147,403,548.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2023 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	-33,254,751.37	1,754,562,031.51
D08	Тайлант үеийн үр дүн			114,778,512.75	114,778,512.75
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	81,523,761.38	1,869,340,544.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Харьц уулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,374,284,500.00	2,227,353,865.96	146,930,634.04	95.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,374,284,500.00	2,227,353,865.96	146,930,634.04	95.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,292,819,800.00	2,149,804,795.96	143,015,004.04	95.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736,068,300.00	1,627,292,971.17	108,775,328.83	95.7
210101	Үндсэн цалин	1,084,987,400.00	916,905,836.37	168,081,563.63	86.7
210102	Нэмэгдэл	606,762,400.00	562,599,904.80	44,162,495.20	94
210104	Урамшуулал	44,318,500.00	147,787,230.00	103,468,730.00	333.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217,008,700.00	203,262,936.53	13,745,763.47	95.6
210201	Тэтгэврийн даатгал	147,565,900.00	135,230,336.53	12,335,563.47	93.5
210202	Тэтгэмжийн даатгал	17,360,700.00	17,008,200.00	352,500.00	100

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	8,680,400.00	8,504,100.00	176,300.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	8,680,400.00	8,504,100.00	176,300.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	34,721,300.00	34,016,200.00	705,100.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,345,200.00	113,345,200.00	0.00	100
210301	Гэрэл, цахилгаан	26,535,200.00	25,630,526.00	904,674.00	96.6
210302	Түлш, халаалт	80,700,000.00	83,796,850.00	-3,096,850.00	103.8
210303	Цэвэр, бохир ус	6,110,000.00	3,917,824.00	2,192,176.00	64.1
2105	Норматив зардал	79,778,100.00	66,446,370.00	13,331,730.00	83.3
210502	Хоол, хүнс	79,778,100.00	66,446,370.00	13,331,730.00	83.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,169,800.00	32,608,148.26	2,561,651.74	92.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,145,800.00	1,145,800.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,024,000.00	31,462,348.26	2,561,651.74	13.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,449,700.00	98,849,170.00	4,600,530.00	96.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,922,000.00	83,321,470.00	4,600,530.00	96.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,527,700.00	15,527,700.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,464,700.00	77,549,070.00	3,915,630.00	95.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,464,700.00	77,549,070.00	3,915,630.00	95.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	73,551,900.00	69,636,270.00	3,915,630.00	94.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,912,800.00	7,912,800.00	0.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,374,284,500.00	2,218,231,600.00	156,052,900.00	95.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,095,740,600.00	2,095,740,600.00	0.00	102
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,740,600.00	2,095,740,600.00	0.00	102
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	118,345,200.00	118,345,200.00	0.00	100
132001	Орон нутгийн төсвөөс	118,345,200.00	118,345,200.00	0.00	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	160,198,700.00	4,145,800.00	156,052,900.00	2.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,145,800.00	1,145,800.00	0.00	100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00	0.00	100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	156,052,900.00	0	156,052,900.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		156,525,814.85	-	156,525,814.85
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		147,403,548.89	-	147,403,548.89
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	60	60	0	100
620001	Удирдах ажилтан	3	3	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	35	35	0	100
620003	Үйлчлэх ажилтан	22	22	0	100

63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	513	513	0	100
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	513	513	0	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд заасан боловсролын сургалтын байгууллагын удирдлага, түүний чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд “Суралцах чадвартай,эрүүл чийрэг бие бялдартай, эерэг хандлагатай суралцагч” гэсэн зорилгын хүрээнд 9 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль,Төсвийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль 2024.01.12-нд нэмэлт, 2024.04.19-нд нэмэлт өөрчлөлт, 2024.05.16-нд өөрчлөлт, 2024.06.05-нд нэмэлт өөрчлөлт, 2024.07.10-нд өөрчлөлт, 2024.12.03-ны өдөр нэмэлт нийт 8 удаа нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2024.01.17, 2024.12.12-ны өдөр 4 удаа нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 2024.01.12, 2024.06.05, 2024.12.12-нд 3 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2024.01.17, 2024.06.05, 2024.08.30-ны өдрүүдэд 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон
- Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 2023 оны 240 дүгээр тогтоол, 2024 оны 84 дүгээр тогтоол
- Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай ЗГ-ын 2023 оны 241 дүгээр тогтоол, 2024 оны 128 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2025.01.02-ны А/03 дүгээр тогтоол "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам "

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь БШУЯ-наас 2017 оны 02 дугаар сарын 17-ны 40 дүгээр тушаалаар баталсан боловсролын салбаруудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөлтийг хийлгээгүй тул нийцэхгүй байна. Стандарт, хууль тогтоомжид нийцсэн бодлогын баримт бичигтэй болох шаардлагатай.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,033.4 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Мөнгөн хөрөнгө	156,525.81	147,403.54	-9,122.27	-5.8
Бараа материал	99,823.22	138,888.90	39,065.68	39.1
Үндсэн хөрөнгө	1,503,958.15	1,583,048.10	79,089.95	5.3
Нийт хөрөнгө	1,760,307.18	1,869,340.54	109,033.36	6.2
Өглөг	5,745.15	0	-5,745.15	-100.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,754,562.03	1,869,340.54	114,778.51	6.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,760,307.18	1,869,340.54	109,033.36	6.2

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос -9,122.27 мянган төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 156,525.81 мянган төгрөг, тайлант оны эцэст 147,403.54 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 5.8 хувиар өссөн нь оны эцэст үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 82,862.6 мянган төгрөг, норматив зардлаас 13,292.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгээс 77,833.2 мянган төгрөгөөр санхүүжилт хэмнэгдсэн холбоотой байна.

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 39,065.68 мянган төгрөгөөр өссөн байна. Бараа материалын данс нь 99,823.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 275,101.2 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 24,296.9, нийт 299,398.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 260,332.4 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 138,888.8 мянган төгрөг байна. Өмнөх оноос өссөн шалтгаан нь аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 79,089.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгө данс нь 1,503,958.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсөв хөрөнгөөр худалдаж авсан 39,398.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 184,649.5 мянган төгрөг нийт 224,048.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлэхээр хөрөнгийг данснаас хассан, акталсан, шилжүүлсэн хөрөнгө байхгүй. Тайлант жилд 144,958. мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулагдаж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,583,048.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант үеийн үр дүнг 114,778.5 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд 20 бүлгийн 593 сурагчдаар тооцож, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,210,887.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 121,345,2 мянган төгрөг, нийт зарлагыг 2,332,232.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 115,146.6 мянга төгрөг буурч, тогтмол зардлыг 3,000.0 мянга төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 2,095,740.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 118,345.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 22 бүлгийн 569 сурагчидтайгаар хичээлийн үйл ажиллагааг явуулсан бөгөөд сар бүрийн тодотголоор батлагдсан төсвөөр санхүүжүүлсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,967,809.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 205,763.7 мянган төгрөгийг урсгал санхүүжилт орон нутгаас, урьд оны үлдэгдлээс 135,338.1 мянган төгрөг, 2,338.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна.

Тайлант онд орон нутгийн санхүүжилтээс 4,299.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,137,845.3 мянган төгрөг буюу 92,21 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 152,062.5 мянган төгрөг, БГАҮТХ-ийн зардал 183.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгээс 7,745.1 мянган төгрөгийг хэмнэж, төрийн сангийн дансанд 177,181.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	мянган төгрөгөөр	
				Зөрүү дүн	Хувь
1	71802-80112 Нийтлэг үйлчилгээ	121,345.20	121,345.20	0.00	100.0
1.1	80312-Сургалт семинар	3,419.60	2,565.50	854.10	75.0
1.2	71802-80226 байр ашиглалт	3,693.90	3,652.10	41.80	98.9
1.3	81801- Үдийн цай хөтөлбөр	73,551.90	69,636.30	3,915.60	94.7
1.4	71802-81823 Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	13,613.80	13,613.80	0.00	100.0
1.5	71802-81605 Эрүүл мэндийг	5,531.20	3,662.10	1,869.10	66.2
1.6	71802-81806 Дотуур байр	300,810.00	247,117.30	53,692.70	82.2
1.8	71802-81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	28,771.50	28,196.20	575.30	98.0
1.9	71802-81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	19,790,7	19,790,8	0.00	100.0
1.1	71802-81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,754,818.10	1,668,836.00	85,982.1	97.4
1.11	71802-81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	57,584.50	57,584.50	0.00	100.0

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан					
1.12	71802-80233 Хүүхэд хамгаалал	3,769.80	3,769.80	0.00	100.0
1.13	71802-81848 Сурх бичгийн түрээс	1,145.80	1145.8	0.00	100.0
1.14	71802-81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	6,229.20	6,229.20	0.00	100.0
	дүн	2,374,284.50	2,227,353.80	146,930.63	95.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллагын төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлд шинжилгээ хийж үзэхэд батлагдсан төсвийн 95.5 хувийг тайлант жилд зарцуулсан байна. Нийт гүйцэтгэлийн 79.1 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, БГБНАҮТХ, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зардлууд нь 9.5 хувийг эзэлж байна. Тус байгууллага нь 180,703.7 мянган төгрөгийн хэмнэсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн тоогоор гүйцэтгэлээр санхүүждэг тул нэмэлт санхүүжилт авдаггүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж нийт 136,082.6 мянган төгрөгийн үнийн дүн бүхий дотуур байрны сурагчдын хоол, үдийн хоолны хүнсний материал худалдан авах тендерийг цахим tender.gov.mn сайтаар зохион байгуулж Балж уул ХХК, Гост трейд ХХК, Гурван цэрэн ХХК, Гэрэлтэх болор ХХК-уудтай гэрээ байгуулан ажилласан байна.

Үндсэн хөрөнгийн тухайд нөхөн хангалтын зардлаас 28,771.5 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардлаас 13,500.0 мянган төгрөг нийт 71,986.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд үүний 13,500.0 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс авсан байна. Харин 25,898.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна. Сургуулийн удирдлагаас нөхөн хангалтын болон менежмент сайжруулахтай холбоотой санхүүжилт нь оны сүүлээр шийдэгддэг бөгөөд тухайн ондоо зарцуулаагүй тохиолдолд зарцуулах эрхийг дараа оны 2-р улирал хүртэл шийдэгддэггүй тул шууд худалдан авалт хийсэн. Ирэх онд зөрчлийг арилгаж ажиллах тайлбар хүсэлт ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

3.5.6 Ерөнхий чиглэлийн судалгааны талаар

- 2024 онд удирдах ажилтан 3, гүйцэтгэх ажилтан 35, үйлчлэх ажилтан 22, нийт 60 хүний бүтэц орон тоотой, 1,700,816.5 мянган төгрөгийн цалингийн сан батлагдсанаас гүйцэтгэлээр 60 ажилтан 1,627,292.9 мянган төгрөгийн цалингийн зардалтай, үүнээс 916,905.8 мянган төгрөгийн үндсэн цалин, 562,599.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, 147,787.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Тайлант жилд нийт 2 орон тоог хавсран ажиллуулсан байна. 2024 оны 04 сарын 01

өдрөөс Засгийн газрын 2024 оны 84, 128 дугаар тогтоолыг үндэслэн ажилчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар нэмж нийт цалингийн сан өмнөх оноос 53.3 хувиар нэмэгдсэн байна. 2024 онд 3 албан хаагч шинээр ажилд авч, 2 албан хаагчийг ажлаас чөлөөлсөн байна.

- Тус байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээрийн зүйлийн 14.7-д заасны дагуу 2024 онд ахмадын сан байгуулаагүй.
- Тайлант жилд тус байгууллага нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 19,108.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 57,422.6 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 15,527.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Ерөнхий чиглэлийн судалгааг ажлын баримтад хавсаргав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бизкон аудит” ХХК Архангай аймаг дахь салбарын аудитор Д.Должинсүрэн, Ц.Отгон-Оюун, Б.Бөхболд, Л.Энхцэцэг нар гүйцэтгэж, арга зүйгээр хангах, удирдан зохион байгуулж үе шатны хяналтыг салбарын захирал Ч.Анхбаяр хэрэгжүүллээ. Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас арга зүйгээр хангах, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, удирдан зохион байгуулж үе шатны хяналтыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бизкон аудит” ХХК Архангай аймаг дахь салбарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны тодотгон батлагдсан төсөв 2,333,378.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,333.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,333.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын

байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 159 мэдээллийг бүрэн оруулж мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг 2024.09.16 - 2024.12.23-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт		0		0	
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	1	0.0	1	0.0	100

Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 06 сарын 10 ны № 42 тоот албан бичгээр хариу өгсөн байна. Шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах зардлуудыг анхаарч үзнэ. Үүнд:

1. Цалин хөлс нэмэгдэл урамшуулал
2. Бараа ажил үйлчилгээний худалдан авалт
3. Бараа үйлчилгээний бусад зардал.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 915.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

- Зардлын зүйл анги зөрүүлж 915.5 мянган төгрөгийн аж ахуйн материалыг 210407 аж ахуйн материалын зардлаар бүртгэснийг 210901 зардлаар бүртгэлд тусгуулж аудитын явцад залруулан бүртгүүлэв. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.2, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.
- Аудитаар нийт 25,898.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг бус алдааны зөрчил нь 186,522.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 16,333.6 мянган төгрөг, материаллаг бус алдаа зөрчил илэрсэн тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1024 ширхэг 160,623.7 мянган төгрөгийн хөрөнгөнд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд 25,898.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасгай" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлын ангилал залруулж бүртгүүлсэн	1	915.5			1	915.5	1	915.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шууд гэрээгээр худалдан авалт хийсэн	1	25,898.9					1	25,898.9				
Үлдэх өртөггүй хөрөнгийн талаар холбогдох арга хэмжээг аваагүй.	1	160,623.8			1	160,623.8						
Дүн	2	186,522.7			1	160,623.8	1	25,898.9				